



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/362

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны 5 дугаар сарын 23 өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын дараах хяналтын арга хэмжээг эрчимжүүлэхэд 678,700 (Зургаан зуун далан найман мянга долоон зуун) төгрөгийг зарцуулсугай.
2. Шүлхий өвчний дархлаажуулалтын дараах хяналтын зардлыг хавсралтаар баталж, хяналтыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа)-д үүрэг болгосугай.
3. Дээрх зардлын 678,700 (Зургаан зуун далан найман мянга долоон зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Мал эмнэлгийн газарт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

